Зураг. 50 Сумын орон нутгийн иргэдэд ажлын явцыг тайлагнасан.

## 12.2 БОМТ-ын зардлын нэгдсэн хүснэгт

Д/д	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Үнийн дүн / мян.төг /	Үнийн дүн / мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6 750.0	6 750.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	8 400.0	37 688.5
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20 000.0	21 500.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3 000.0	3 000.0
7	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	3 700.0	3 700.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)	2 620.0	2 620.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500.0	500.0
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-	-
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт		44 970.0	75 758.5

Хүснэгт. 5 БОМТ-ын зардлын хүснэгт

### 13. ДҮГНЭЛТ

2023 онд биологийн нөхөн сэргээлтийг хадлан бэлчээрийн чиглэлээр хийсэн болно. Тарилтанд олон наст тухайн орон нутагт элбэг тархацтай ботуул, согоовор ерхөг гэсэн өвслөг ургамал мөн нэг наст тэжээлийн ургамал овъоёс, судан өвсийг 1:1:1:1 гэсэн харьцаатай үрийн холимог ашиглав. Тэжээлийн ургамал нь хөрсийг үндэсний системээр баяжуулан хөрсний шимэрхэг чанарыг дээшлүүлж, салхин нөмрөг үүсгэж өгдөг үр ашигтай. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хашиж хамгааллаж усалгаа арчилгаа хийснээр ургамлын ургалтын бүхий л үе шат хэвийн сайн явагдсан бөгөөд 9 сарын сүүлийн 10 хоногт үр боловсролт гүйцэж үрээ хаясан болно. Төлөвлөгөөт онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн ба бид тайланд төлөвлөгөөт аудит хийлгэсэн мөн “ Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд 2000 ширхэг мод тарилаа. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллаа. Бид цаашдын үйл ажиллагаандаа Монгол улсад мөрдөгдөж байгаа байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын стандарт нормуудыг баримтлан ажиллана.



УБ-2

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



# МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000098799

2015.04.28

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011528127

/ Улсын бүртгэлийн дугаар /

5958989

/ Регистрийн дугаар /

Хавчигийн ам

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2015.04.22

/ он, сар, өдөр /

4610

/ код /

Гадаад худалдаа

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

8299

7220

4659

Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх

Геологийн суурь судалгаа хийх

Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1


/ гишүүдийн тоо /

20.00

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянзүрх, 1-р хороо, 52, 42 тоот, Утас1: 99087797, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Улсын бүртгэлийн ерөнхий  
газрын Бүртгэлийн Газар

/ бүртгэсэн байгууллагын дугаар /

### Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Голомт банк	Төгрөгийн	3455101809	Ч.Батдэлгэр 11/101

### Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Монхор овогтой Пүрэвцогт-г Захирал-р томилсныг бүртгэв.	2015.04.28	Ч.Батдэлгэр
2	Улаанбаатар, Баянзүрх, 25-р хороо, 13 хороолол, эрэл, 40, 37 тоот, Утас1 99112133, Утас2 99091440, Факс хаягийг шинээр бүртгэв.	2019.05.06	Х.Түвшинтөр 175
3	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2019.05.06	Х.Түвшинтөр
4	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2019.05.17	С.Мөнхсанчир
5	Бямба овогтой Баярбаатар-г Гүйцэтгэх захирал -р томилсоныг бүртгэв.	2019.09.16	Д.Чулуунтуяа
6	Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, зайсан, Гэгээнтэн, 201 байр, 13 давхар, 1303 тоот Утас1: 70002200, Утас2: 88113110, Факс: хаягийг шинээр бүртгэв.	2020.02.05	С.Цолмон
7	08990 Ашигт малтмал ашиглалт /2020.01.06-2050.01.06/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.02.05	С.Цолмон

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.  
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.







АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ  
**ЗӨВШӨӨРӨЛ**

Дугаар *MV-021514*

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Төв аймаг /хот/-ийн

Заамар сум /дүүрэг/-ын

Бумбат-4 нэртэй газарт орших

1139.97 гектар талбай бүхий уурхайн талбайд

хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 9011528127 тоот гэрчилгээтэй

"Хавчигийн ам" ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 2050.01.06 дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Одончимэг*

2020 оны 1 сарын 6 өдөр

Улаанбаатар хот

0000411



# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

**MV-021514**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	• Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2020.01.06	1139.97 Га	0 Га	1	104° 35' 13.74"	48° 18' 9.52"
				2	104° 35' 13.76"	48° 18' 6.28"
				3	104° 35' 21.04"	48° 18' 6.31"
				4	104° 35' 21.19"	48° 17' 46.89"
				5	104° 35' 41.72"	48° 17' 27.54"
				6	104° 35' 49.47"	48° 17' 30.79"
				7	104° 36' 1"	48° 17' 30.79"
				8	104° 36' 1"	48° 15' 16.18"
				9	104° 35' 15.27"	48° 15' 16.18"
				10	104° 35' 15.27"	48° 15' 35.82"
				11	104° 34' 33.31"	48° 15' 35.82"
				12	104° 34' 33.31"	48° 15' 9.93"
				13	104° 33' 59.38"	48° 15' 9.93"
				14	104° 33' 59.38"	48° 14' 41.81"
				15	104° 33' 54"	48° 14' 41.81"
				16	104° 33' 54"	48° 14' 42"
				17	104° 33' 53.3"	48° 14' 42"
				18	104° 33' 53.3"	48° 14' 41.81"
				19	104° 32' 54"	48° 14' 41.81"
				20	104° 32' 54"	48° 14' 48.81"
				21	104° 33' 31"	48° 14' 48.81"
				22	104° 33' 31"	48° 16' 33.82"
				23	104° 33' 55"	48° 16' 33.82"
				24	104° 33' 55"	48° 16' 45.82"
				25	104° 35' 7.01"	48° 16' 45.82"
				26	104° 35' 7.01"	48° 17' 1.82"
				27	104° 34' 43"	48° 17' 1.82"
				28	104° 34' 43"	48° 17' 43.83"
				29	104° 35' 5"	48° 17' 43.83"
				30	104° 35' 5"	48° 18' 9.51"
				31	104° 35' 8.89"	48° 18' 9.51"

3  
КАДАСТРИЙН ДЭЛГЭС  
2020-01-06  
УХ 19525  
Д.Мягмарсүрэн





# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

**MV-021514**

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2020.01.06, дуусах хугацаа 2050.01.06</li><li>Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв</li><li>Кадастрын хэлтсийн даргын 2020.01.02-ний 1 тоот шийдвэр</li></ul>	2020.01.06 
002-PL	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9016001014 тоот улсын бүртгэлийн дугаартай Голомт банканд барьцаалах</li><li>Кадастрын хэлтсийн даргын 2020.09.11-ний 341 тоот шийдвэр</li></ul>	 2020.09.11
003-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.01.06 – 2022.01.06 хүртэл</li></ul>	 2021.01.18
004-PC	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг 9016001014 тоот улсын бүртгэлийн дугаартай Голомт банканд давхар барьцаалсныг (барьцааны гэрээний дугаар 2021 оны БГ8145101393-1, БГ8145101394-1) бүртгэв.</li><li>ГУУКХ-ийн даргын 2021.09.02-ны 334 тоот шийдвэр</li></ul>	 2021.09.02
005-FE	<ul style="list-style-type: none"><li>Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.01.06 – 2023.01.06 хүртэл</li></ul>	 2022.01.10




# ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

## Кадастрын лавлагаа

### Лавлагааны мэдээлэл

Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашиг малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021514
Талбайн нэр	Бумбат-4
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	1139.97
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Хавчигийн ам
Аймаг, сум, сав газрын нэр	Төв аймаг Заамар сум, Туул голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалгүй
Давхацсан талаарх мэдээлэл	



### ТАНИХ ТЭМДЭГ

#### Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

- Ашиглалтын
- Хайгуулын

#### Засаг захиргааны хил

- Улсын хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Аймгийн төв
- Сумын төв

#### Тусгай хамгаалалттай газар нутаг

- Дархан цаазат газар
- Байгалийн цогцолборт газар
- Байгалийн нөөц газар
- Дурсгалт газар

#### Хамгаалалтын бүсүүд

- Гол мөрний урсац бүрэлдэх эх
- Ойн сан бүхий газар

#### Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

- Онцгой хамгаалалтын бүс
- Энгийн хамгаалалтын бүс

#### Ус хангамжийн эх үүсвэр

- Эрүүл ахуйн хориглолтын бүс
- Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
- Тэжээгдлийн муж

#### Орон нутгийн усны хамгаалалтын бүс

- Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:56828.0







МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УСНЫ ГАЗАР**

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,  
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050  
Утас/Факс: (976-51) 26 55 78, (976-51) 26 55 36,  
Цахим шуудан: office@water.gov.mn,  
Цахим хуудас: www.water.gov.mn

2023.06.15 № 05/903


танай 2023.05.17 ны № 23/11 -Т


“ХАВЧИГИЙН АМ” ХХК-Д

Танай байгууллагын 2023 оны 23/11 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг судалж үзээд Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт заасны дагуу Төв аймгийн Заамар сумын нутагт хэрэгжиж байгаа ашигт малтмалын MV-021514 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий “Бумбат-4” алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг: Туул голын сав газрын захиргаанд

Хавсралт: 4 хуудаастай.

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Х.МЯГМАРЖАВ



162331811

## УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 06 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар: 136

Улаанбаатар хот  
Утас: 51-265528

### 1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

"Хавчигийн ам" ХХК, гүйцэтгэх захирал Б.Баярбаатар, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Зайсангийн гудамж, 201-р байр, 13 давхар, 1303 тоот. Утас: 8811-3110, улсын бүртгэлийн дугаар: 9011528127, регистрийн дугаар: 5958989.

### 2. Төслийн нэр, байршил

"Бумбат-4" алтны шороон ордыг ашиглах төсөл нь Улаанбаатар хотоос баруун хойш 200 км, Заамар сумын төвөөс баруун хойш 20 км, "Шижир алт" суурингаас 15 км-т зайд байрлана. Туул голын сав газарт хамаарагдана.

### 3. Төсөл хэрэгжүүлэгч

"Хавчигийн ам" ХХК.

### 4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X, Y/

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021514, Талбайн хэмжээ: 1,139.97 га.

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104° 35' 13.74"	48° 18' 9.52"	30	104° 35' 05"	48° 18' 09.51"
2	104° 35' 13.76"	48° 18' 6.28"	31	104° 35' 08.89"	48° 18' 09.51"

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний 2 дугаар хавсралтад нийт 31 цэгээр лицензийн талбайг тогтоосон байна.

### 5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт

Алтны шороон ордыг ил аргаар олборлон, баяжуулах.

### 6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/

Уурхайн олборлолтод ашиглах машин техник:

CATERPILLAR маркийн эксковатор 7 ш	HOWO маркийн автосамосвал 20 ш
HYUNDAI маркийн эксковатор 2 ш	CATERPILLAR маркийн автосамосвал 2 ш
LIUGONG маркийн утгуурт ачигч 5ш	CATERPILLAR маркийн бульдозер 2 ш

Баяжуулалтад ашиглах тоног төхөөрөмж:

СБ-60 маркийн хүрдэт шигшүүр 1 ш	Хоригт цорго гравитаци 1 ш
----------------------------------	----------------------------

Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж цагийн хүчин чадал:

СБ-60 маркийн хүрдэт шигшүүр 50 м <sup>3</sup> /цаг
---

2023 онд 274 хүн хоногт 2 ээлжээр 10 цаг, 240 хоног ажиллахаар төлөвлөсөн байна.


### 7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ

2023 онд 8,398.62 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 196.77 мян.м<sup>3</sup> элс олборлон баяжуулж, 196.83 кг алт гарган авна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2 га талбайд 2,000 ш мод тарина, биологийн нөхөн сэргээлт 2.1 га талбайд хийхээр төлөвлөсөн байна.

### 8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/

Унд, ахуйн хэрэглээнд шаардагдах усыг 0.5 л/сек ундаргатай гүний худгаас, технологи, зам талбайн тоосжилт дарах усыг зэргэлдээ төслийн талбай дахь үүсмэл нуураас хангахаар төлөвлөсөн байна.

Усны газрын 2023 оны 01/391 тоот усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд "Хавчигийн ам" ХХК-ийн хэрэгжүүлэх "Бумбат-4" алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах





төслийн усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна. Унд ахуйд 36 м<sup>3</sup>/хон усыг хэрэглэнэ.

**9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, хэмжээ хийц, дамжуулах шугам сүлжээний урт, диаметр/**

Баруун шандын хэсгийн эргэлтийн усан сангийн эзэлхүүн: 35 мян.м<sup>3</sup>, Тунаах сангийн эзэлхүүн: 178 мян.м<sup>3</sup>, Цагаан чулуутын хэсгийн эргэлтийн усан сангийн эзэлхүүн: 25 мян.м<sup>3</sup>, тунаах сангийн эзэлхүүн: 75 мян.м<sup>3</sup>.

**10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур, /насосны хүчин чадал, марк/**

№	Уртраг	Өргөрөг	Ундарга (л/с)	Насосны марк	Тоолуурын	
					Марк	Дугаар
1	104°34'10.1"	48°16'24.6"	0.5	-	-	-

**11. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл**

Төв аймгийн Заамар сумын нутаг дахь “Бумбат-4” алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг 2023 онд “Хавчигийн ам” ХХК-ийн захиалгаар “Говьхангайн төгөл” ХХК боловсруулж, батлуулсан.

**12. Онцгой нөхцөл**

- Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлэх шаардлагатайг анхаарах.

**13. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалт:**

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд жилд:

$$196,770 \text{ м}^3/\text{жил} \times 4.0 \text{ м}^3/\text{тн} = 787,080 \text{ м}^3/\text{жил} \text{ ус шаардагдана.}$$

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал:

Элсийг угаах хүрдэт шигшүүрийн цагийн хүчин чадал 50 м<sup>3</sup>, (2023 оны АҮАТ-ний Маягт-7)

50 м <sup>3</sup> /цаг х 20 цаг/хон = 1,000 м <sup>3</sup> /хон	- хоногт угаах элсний хэмжээ
1,000 м <sup>3</sup> /хон х 4 м <sup>3</sup> = 4,000 м <sup>3</sup> /хон	- хоногт шаардагдах усны хэмжээ
4,000 м <sup>3</sup> /хон х 5 хон = 20,000 м <sup>3</sup>	- эргэлтийн усан санд тогтмол байлгах усны хэмжээ
196,770 м <sup>3</sup> /жил : 1,000 м <sup>3</sup> /хон = 196 хон	- элс угаан баяжуулахад зарцуулах хугацаа
4,000 м <sup>3</sup> /хон х 0.2 х 196 хон = 156,800 м <sup>3</sup> /жил	- ууршилт, шүүрэлтээр алдагдах усны хэмжээ
20,000 м <sup>3</sup> + 156,800 м <sup>3</sup> = 176,800 м <sup>3</sup> /жил	- үйлдвэрлэлийн технологид ашиглах нийт усны хэмжээ
67,296 м <sup>2</sup> х 2 л/м <sup>2</sup> х 150 хон = 20,188.8 м <sup>3</sup> /жил	- зам, талбайн тоосжилт дарахад ашиглах ус (БОННУ нэмэлт тодотгол тайлангийн 96-р хуудас)
2,000 ш х 50 л х 9 удаа = 900 м <sup>3</sup> /жил	- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод (2023 оны АҮАТ-ний Маягт-10)
1,111 ш х 50 л х 18 удаа = 499.95 м <sup>3</sup> /жил	- Өмнөх жилийн мод усалгаанд
176,800 + 20,188.8 + 900 + 499.95 = 198,388.75 м <sup>3</sup> /жил	- Жилд ашиглах нийт усны хэмжээ



**Унд, ахуйн усны нийт хэрэгцээнд:**

274 хүн x 150 л/хон x 240 хон = 9,864 м<sup>3</sup>/жил

**14. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны төлбөрийн хэмжээ**

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд, ахуйн зориулалтаар ашиглах 9,864 м<sup>3</sup>/жил усыг төлбөрөөс чөлөөлнө.

Ашигт малтмал баяжуулахад ашиглах 176,800 м<sup>3</sup>/жил, зам, талбайн тоосжилт дарахад ашиглах 20,188.8 м<sup>3</sup>/жил, биологийн нөхөн сэргээлт, ногоон байгууламж, мод услахад ашиглах 1,399.95 м<sup>3</sup>/жил гадаргын усны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор баталсан Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326, 2022 оны 416 дугаар тогтоолд заасан хувь, хэмжээг ашиглан усны нөөц ашигласны төлбөрийг урьдчилсан байдлаар тооцвол:

*Ашигт малтмал баяжуулахад гадаргын усны нөөц ашигласны төлбөр:*

1 м<sup>3</sup> гадаргын усны үнэ: 2651 төг/м<sup>3</sup> x 0.25 x 0.9 = 596.475 төг

2651 төг/м<sup>3</sup>: Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

25%: Засгийн газрын 416-р тогтоолын 7(а)-д заасан ашигт малтмал баяжуулахад гадаргын ус ашигласныг тооцох төлбөрийн хувь;

0.9: Туул голын сав газарт ашигт малтмал баяжуулахад гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр.

**176,800 м<sup>3</sup> x 596.475 төг = 105,456,780 төг**

*Уурхайн зам, талбайн тоосжилт дарахад гадаргын усны нөөц ашигласны төлбөр:*

1 м<sup>3</sup> гадаргын усны үнэ: 2651 төг/м<sup>3</sup> x 0.1 x 0.3 = 79.53 төг

2651 төг/м<sup>3</sup>: Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

10%: Засгийн газрын 326-р тогтоолын 4-д заасан гадаргын ус ашигласныг тооцох төлбөрийн хувь хэмжээ;

0.3: Туул голын сав газарт авто замын зориулалтаар гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр.

**20,188.8 м<sup>3</sup> x 79.53 төг/м<sup>3</sup> = 1,605,615.26 төг**

*Биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах, мод тарихад гадаргын усны нөөц ашигласны төлбөр:*

1 м<sup>3</sup> гадаргын усны үнэ: 2651 төг/м<sup>3</sup> x 0.01 x 0.7 = 18.557 төг

2651 төг/м<sup>3</sup>: Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ;

1%: Засгийн газрын 326-р тогтоолын 9-д заасан газар тариалангийн үйлдвэрлэлд гадаргын ус ашигласныг тооцох төлбөрийн хувь;

0.7: Туул голын сав газарт ногоон байгууламжийн зориулалтаар гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр.

**1,399.95 м<sup>3</sup> x 18.557 төг = 25,978.87 төг**

**Нийт төлбөр: 105,456,780 + 1,605,615 + 25,979 = 107,088,374 төгрөг**

***/Нэг зуун долоон сая наян найман мянга гурван зуун далан дөрвөн төгрөг/***





**15. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар**

- Ахуйн бохир усыг зохих стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, халдваргүйжүүлэн зам, талбайн тоосжилт, биологийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Нөхөн сэлбэлтээр авах усны хэмжээг 30%-иас хэтрүүлэхгүй байх.

**16. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө**

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрт баталгаажуулсан тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны нөөц ашигласны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах.
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед Сав газрын захиргаа болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж, тухайн оны ус ашиглалтын тайланд тусгаж ирүүлэх;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор Усны газарт [office@water.gov.mn](mailto:office@water.gov.mn) цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах;

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б.ГАНТОГТОХ



ТУУЛ ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 23/14 дугаартай албан бичиг, "Усны газар"-ын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 05/703 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 136 тоот "Ус ашиглуулах дүгнэлт"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-021514 тусгай зөвшөөрөлтэй "Бумбат-4"-ийн алтны шороон ордоос 196'770.0 м<sup>3</sup> элс угаахад үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд шаардагдах 198'388.75 м<sup>3</sup> усыг зэргэлдээ төслийн талбай дахь үүсмэл нуураас, унд ахуйн хэрэглээний 9'864.0 м<sup>3</sup> усыг өөрийн эзэмшлийн 1 худгаас 2023 онд ашиглахыг "Хавчигийн ам" ХХК-д зөвшөөрсүгэй.

2. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны ахлах мэргэжилтэн /Д.Уранчимэг/, Туул голын сав газрын захиргааны менежер /Б.Батцэцэг/ нарт үүрэг болгосугай.


3. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 30 дугаар зүйлд заасан ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Сав газрын захиргаанд ирүүлэхийг "Хавчигийн ам" ХХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Баярбаатар/-д даалгасугай.

УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ  
ЗОХИЦУУЛАХ АЛБАНЫ ДАРГА:



П.ЭНХБАЯР





П.ЭНХБАЯР



Б.БАЯРБААТАР

## УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 23/31

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Усны газар"-ын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 05/703 дугаар албан бичгийн хавсралт 136 тоот ус ашиглуулах дүгнэлт, Туул голын сав газрын захиргааны даргын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/11 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны мэргэжилтэн Э.Мягмарсүрэн, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Зайсангийн гудамж, 201-р байр, 13 давхар, 1303 тоотод байрлах Улсын бүртгэлийн 9011528127 тоот гэрчилгээ, 5958989 тоот регистрийн дугаартай "Хавчигийн ам" ХХК-ийн Төлөвлөлтийн инженер Г.Ренчинсангиа нар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. *Ус ашиглах зориулалт:* Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-021514 тусгай зөвшөөрөлтэй "Бумбат-4"-ийн алтны шороон ордын үйлдвэрлэл, технологийн хэрэглээний усыг зэргэлдээ төслийн талбай дахь үүсмэл нуураас, унд ахуйн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн гүний 1 худгаас ашиглана.

2.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4.4-т заасны дагуу 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 196'770.0 м<sup>3</sup> элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд зарцуулах ус 208'252.75 м<sup>3</sup>/жил;

2.2.1. Унд ахуйд ашиглах ус: 9'864.0 м<sup>3</sup>/жил;

2.2.2. Ашигт малтмал олборлох, баяжуулахад ашиглах гадаргын ус: 176'800.0 м<sup>3</sup>/жил;

2.2.3. Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах гадаргын ус: 20'188.8 м<sup>3</sup>/жил;

2.2.4. Модны усалгаанд: 1'399.95 м<sup>3</sup>/жил.

2.3. *Усны чанар, найрлага:* 2023 оны 06, 09, 11 дүгээр сард хаягдлын нуурын уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Зэргэлдээ төслийн талбай дахь үүсмэл нуураас 2.2 км зайд шугам хоолойгоор ус татна. Унд, ахуйн хэрэгцээний усыг өөрийн эзэмшлийн талбайд байрлах 0.5 л/сек ундаргатай худгаас ашиглана.

2.4.2. *Барилга байгууламж*: Баруун шандын хэсгийн Эргэлтийн усан сан 35'000.0 м<sup>3</sup>, тунаах сан 178'000.0 м<sup>3</sup>, Цагаан чулуутын хэсгийн эргэлтийн усан сан 25'000.0 м<sup>3</sup>, тунаах сан 75'000.0 м<sup>3</sup> эзлэхүүнтэй.

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк*: Caterpillar маркийн экскаватор 7ш, Caterpillar маркийн бульдозер 2ш, Caterpillar маркийн автосамосвал 2ш, Howo маркийн автосамосвал 20ш, Hyundai маркийн эксковатор 2ш, Liugong маркийн утгуурт ачигч 5ш, СБ-60 маркийн хүрдэт шигшүүр 1ш, хоригт цорго гравитаци 1ш, СБ-60 маркийн хүрдэт шигшүүр 50 м<sup>3</sup>/цаг 1ш, тус тус ашиглана.

2.4.4. *Насосны хүчин чадал*: Зэргэлдээ төслийн талбай дахь үүсмэл нуураас эргэлтийн усан санд ус дамжуулах хуванцар хоолойгоор 2.2 км хоолойгоор ус дамжуулна. Нуураас угаах төхөөрөмжид Д-200-45, Д-200-80 маркийн насосоор 150 мм голчтой, 250 м хоолойгоор ус дамжуулна.

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага*: Тунгаах сангийн усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015" стандартыг мөрдлөг болгоно.

2.5.1. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу төлбөр тооцно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин*:

2.6.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан "Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам"-ын дагуу төлбөр тооцно.

2.6.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам"-ын дагуу тохижуулж ашиглана.

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ*: Усны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

2.7.1. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах.

2.8. *Усны тоолуур*: Усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж, ус татаж буй насосны гаралт дээр тоолуур суурилуулна. Тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтлөж, баталгаажуулна.

2.8.1. Гэрээнд заагаагүй эх үүсвэрээс ус ашигласан нөхцөлд угаасан элсний хэмжээг уулын ажлын тайланг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын дагуу ашигласан усны зарцуулалтын хэмжээг тооцно.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ*:

2.9.1. Ашигт малтмал олборлох, баяжуулахад ашиглах 176'800.0 м<sup>3</sup> гадаргын усны нөөц ашигласны төлбөрт 105'456'780.0 /Нэг зуун таван сая дөрвөн зуун тавин зургаан мянга долоон зуун наян/ төгрөг, зам, талбайн тоосжилт дарахад шаардагдах 20'188.8 м<sup>3</sup> гадаргын усны нөөц ашигласны төлбөрт 1'605'615.0 /Нэг сая заргаан зуун таван мянга зургаан зуун арван таван/ төгрөг, мод усалгаанд ашиглах 1'399.95 м<sup>3</sup> гадаргын усны төлбөрт нийт 25'979.0 /Хорин таван мянга есөн зуун далан есөн/ төгрөг, нийт 107'088'374.0 /Нэг зуун долоон сая наян найман мянга гурван зуун далан дөрвөн/ төгрөгийг Төв аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 40 хувийг хоёрдугаар, 60 хувийг гуравдугаар улиралд төлнө.



2.9.2. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-д заасны дагуу төлбөр тооцно.

#### Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.6, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

#### Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд жил бүрийн ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг тухайн оны эхний улиралд багтаан байгуулна.

4.3. Тайлант оны уулын ажлын гүйцэтгэлийн тайлан, ус ашиглалтын тайланг үндэслэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг 2 хувь үйлдэн баталгаажуулах бөгөөд гэрээнд заасан төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд дараа оны гэрээ хийгдэхгүй.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж буй усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцөлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
албаны ахлах мэргэжилтэн

Төлөвлөлтийн инженер



Д.УРАНЧИМЭГ



Г.РЕНЧИНСАНГИА

Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах  
албаны мэргэжилтэн

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Зайсангийн гудамж, 201-р байр, 13 давхар, 1303 тоот



Э.МЯГМАРСҮРЭН

Харилцах утас: 8811-3110, 8903-7388.

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр, 203 тоот өрөө.

Харилцах утас: (976) 7000-3716, (976) 7000-3714.



Нэгж талбарын дугаар: 4127041923  
 Улсын бүртгэлийн дугаар: Э-1415000088  
 Гэрчилгээний дугаар: 0000057002

**ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР  
 ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны 5 сарын 30 өдөр

№ 04152-2022/00017

*Тов аймаг/хот Заамар сум/дүүрэг*

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, Тов аймаг /нийслэл/-ийн Заамар дүүрэг /сум/-ын Засаг даргын 2022 оны 03 сарын 25-ны өдрийн 04152-а48/2022 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, Тов аймаг/хотын Заамар сум/дүүргийн Газрын албаны мэргэжилтэн Мөнхбат овогтой Цэдэвсүрэн, газар эзэмшигчийг төлөөлж Хавчиггийн ам ХХК-ны Гүйцэтгэх захирал Б.Баярбаатар нар энэхүү гэрээг байгуулав.

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ

11399511 м2

Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт Нөөц газар

Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ 11399511 м2

Газар эзэмших хугацаа 15 жил

2.2. Газар эзэмших эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн хуульд заасны дагуу газрын төлбөрийг тооцож ногдуулна.

2.3. Газрын төлбөрийг нэхэмжлэхийн дагуу Татварын албанд тушаана. Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

2.4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг 30 хоногийн дотор шинэчлэн ногдуулна.

**Гурав. Газар эзэмшигчийн эрх**

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруугай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /*Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах*/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.



## Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

- 4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
- 4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
- 4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх/ 5 жилд нэг удаа хийлгэнэ./;
- 4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- 4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хуульд заасан хугацаанд нь төлөх;
- 4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах;
- 4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах;
- 4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх;
- 4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх;
- 4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.
- 4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх;
- 4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах;
- 4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.
- 4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах;
- 4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах;
- 4.19. Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчлгаа хийх;
- 4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

### Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

- 5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;
- 5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:
  - а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
  - б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх;
  - в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах;
  - г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.
  - д. Барилгын зургийг эрх бүхий мээгэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах;



е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлдээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүд мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлдээгүй; эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр\* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй\* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

ё. Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

### Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл газар эзэмших эрх мөн адил шилжих болно, гэж шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь газрын тухай хуулийн 48-р зүйлд заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь толж барагдуулаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Жич: “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ...” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

“... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

#### Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлдээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



